



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/03/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.10 № 1302/17

танай _____ -ны № _____ -т

АСГАТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Д.БАТБИЛЭГ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

15.9 сая төгрөгийн зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, 2.3 сая төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг жолооч бичээгүй, эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй, батлагдсан орон тооноос 1 гэрээт ажилтныг ажиллуулан 5.6 сая төгрөгийн цалин олгосон зэрэг зөрчлүүд нь (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 20.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 2 стандартын заалттай нийцэхгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

012021874

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,825.98	18,598.90
33	АВЛАГА	132.88	730.00
33500	Бусад авлага	132.88	730.00
33510	Байгууллагаас авах авлага	132.88	730.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,693.10	17,868.90
35400	Хангамжийн материал	16,693.10	17,868.90
35410	Бичиг хэргийн материал	1,148.50	1,186.30
35420	Аж ахуйн материал	15,104.60	15,104.60
35440	Түлш, шатах тослох материал	-	1,038.00
35450	Барилгын засварын материал	440.00	540.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	715,302.85	674,437.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	715,302.85	674,437.73
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	691,509.98	651,124.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	447,095.75	447,095.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,961.33)	(90,896.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,059.80	73,059.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(41,275.73)	(49,011.53)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	315,203.96	321,303.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,446.31)	(83,686.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,812.07	11,812.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,933.55)	(11,072.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,489.25	63,489.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,234.91)	(32,669.09)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	1,700.97	1,700.97
39300	Биет бус хөрөнгө	23,792.88	23,312.88
39301	Програм хангамж	3,667.00	3,667.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,349.50)	(1,829.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,475.38	21,475.38
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	732,128.83	693,036.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	259.16	30.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	259.16	30.00
41300	Өглөг	259.16	30.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	163.91	-

41360	Бусад өглөг	95.25	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	95.25	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	731,869.68	693,006.63
51	Засгийн газрын хувь оролцоо	731,869.68	693,006.63
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	314,097.42	314,097.42
51200	Хуримтлагдсан үр дүн	236,301.77	197,438.72
51210	Өмнөх үеийн үр дүн	219,515.62	236,301.77
51220	Тайлант үеийн үр дүн	16,786.15	(38,863.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,470.49	181,470.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	732,128.83	693,036.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	332,607.12	305,912.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,685.52	2,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	49,685.52	2,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	49,685.52	2,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	282,921.60	303,412.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	239,415.90
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	239,415.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,334.70	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,334.70	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	280,586.90	9,976.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,586.90	9,976.88
1330	Төсвийн захирагчдаас	-	54,019.26
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	54,019.26

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	315,820.97	344,775.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,820.97	344,775.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,376.79	344,166.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,204.80	186,614.19
210101	Үндсэн цалин	189,204.80	166,986.49
210105	Гэрээт ажлын хөлс	-	19,627.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,622.70	27,667.80
210201	Тэтгэврийн даатгал	15,574.23	20,198.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,890.02	1,867.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,512.02	1,517.00
210204	Ажилгүйдлийн даатгал	331.12	350.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,315.31	3,734.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,475.40	31,919.88
210301	Гэрэл, цахилгаан	1,970.78	2,913.46
210302	Түлш, халаалт	29,504.62	29,006.42
2104	Хангамж, бараа материалын зардал	15,876.64	14,305.68
210401	Бичиг хэрэг	5,257.75	2,678.80
210402	Тээвэр, шатахуун	8,613.83	8,772.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,005.06	1,854.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,449.20	755.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	242.20	-
210604	Урсгал засвар	4,207.00	755.40
2107	Томилолт, зочны зардал	2,400.00	3,410.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	2,400.00	3,410.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,199.15	2,226.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,022.59	819.38

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	304.97	469.04
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148.89	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44.00	28.58
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353.40	203.40
210807	Газрын төлбөр	93.19	246.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,148.90	77,267.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,100.00	30,201.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,745.50	46,965.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	444.17	608.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		- 608.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		- 608.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	444.17	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	228.70	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	215.47	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,786.15	(38,863.05)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	16,786.15	(38,863.05)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314097.4	173447.1	223566.2	711110.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	8023.4	-4050.6	3972.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314097.4	181470.5	219515.6	715083.5
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	16786.2	16786.2

10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314097.4	181470.5	236301.8	731869.7
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	314097.4	181470.5	236301.8	731869.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314097.4	181470.5	-38863.0	731869.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	314097.4	181470.5	197,438.7	693,006.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	282,921.60	303,412.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	282,921.60	303,412.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	239,415.90
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	239,415.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,334.70	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,334.70	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	280,586.90	9,976.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,586.90	9,976.88
132002	Хаагдсан данс	-	-
1330	Төсвийн захирагчдаас	-	54,019.26
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	54,019.26
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,671.80	299,812.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,671.80	299,812.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,227.62	299,203.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,743.20	186,873.35
210101	Үндсэн цалин	167,115.50	167,245.65
210105	Гэрээт ажлын хөлс	19,627.70	19,627.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,210.30	27,667.80
210201	Тэтгэврийн даатгал	17,740.60	20,198.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,867.40	1,867.40

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,493.90	1,517.00
210204	Ажилгүйдлийн даатгал	373.50	350.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,734.90	3,734.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,500.38	32,687.00
210301	Гэрэл, цахилгаан	1,734.60	2,913.46
210302	Түлш, халаалт	29,765.79	29,773.54
2104	Хангамж, бараа материалын зардал	15,115.89	13,248.08
210401	Бичиг хэрэг	5,736.60	2,483.20
210402	Тээвэр, шатахуун	7,374.23	8,910.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,005.06	1,854.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,655.30	1,855.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	281.80	-
210604	Урсгал засвар	4,373.50	1,855.40
2107	Томилолт, зочны зардал	2,400.00	3,410.00
210702	Дотоод албан томилолт	2,400.00	3,410.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,199.15	2,226.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,022.59	819.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	304.97	469.04
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119.09	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	28.58
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353.40	203.40
210807	Газрын төлбөр	93.19	246.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,403.40	31,235.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,100.00	30,931.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	444.17	608.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	608.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	608.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	444.17	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	228.70	-
213404	Хөрөнгийн	-	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	215.47	-

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,249.80	3,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,249.80	3,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,249.80	3,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,249.80	3,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,249.80	3,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,249.80)	(3,600.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	292,947.00	292,826.66	292,856.66	(30.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,947.00	292,826.66	292,856.66	(30.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,947.00	292,826.66	292,856.66	(30.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,873.40	186,873.35	186,873.35	-
210101	Үндсэн цалин	167,245.70	167,245.65	167,245.65	-
210105	Гэрээт ажлын хөлс	19,627.70	19,627.70	19,627.70	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,210.30	25,210.30	25,210.30	-
210201	Тэтгэврийн даатгал	17,740.60	17,740.60	17,740.60	-
210202	Тэтгэмжийн даатгал	1,867.40	1,867.40	1,867.40	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,493.90	1,517.00	1,493.90	23.10
210204	Ажилгүйдлийн даатгал	373.50	350.40	373.50	(23.10)
210205	Эрүүл мэндийн даатгал	3,734.90	3,734.90	3,734.90	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,987.20	31,987.11	31,987.11	-
210301	Гэрэл, цахилгаан	2,212.20	2,213.57	2,213.57	-
210302	Түлш, халаалт	29,775.00	29,773.54	29,773.54	-
2104	Хангамж, бараа материалын зардал	11,644.10	13,248.08	11,554.80	1,693.28
210401	Бичиг хэрэг	2,711.70	2,483.20	2,242.70	240.50

Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	7,077.60	8,910.08	7,457.30	1,452.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,854.80	1,854.80	1,854.80	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,455.40	4,455.40	4,455.40	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600.00	3,600.00	3,600.00	-
210604	Урсгал засвар	855.40	855.40	855.40	-
2107	Томилолт, зочны зардал	3,410.80	3,410.00	3,410.00	-
210702	Дотоод албан томилолт	3,410.80	3,410.00	3,410.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,407.20	1,407.11	1,407.11	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10	232.10	-
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.04	469.04	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	227.70	227.70	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	28.60	28.58	28.58	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	203.40	203.40	-
210807	Газрын төлбөр	246.30	246.29	246.29	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,958.60	26,235.32	27,958.60	(1,723.28)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,655.20	25,931.92	27,655.20	(1,723.28)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40	303.40	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	292,947.00	303,382.05	292,856.66	10,525.38
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	293,405.16	292,856.66	548.50
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	293,405.16	292,856.66	548.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	263,191.80	9,976.88	-	9,976.88
320001	Орон нутгийн төсвөөс	263,191.80	9,976.88	-	9,976.88
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	29,755.20	-	-	-

350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	29,755.20	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	0	19
620001	Удирдах ажилтан	6	6	0	6
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	0	8
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	2
620004	Гэрээт ажилтан	3	3	0	3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Асгат сумын ЗДТГ нь Иргэд олон нийтийн санал, санаачлагад тулгуурлан төрийн үлчилгээг иргэн бүрт шуурхай, жигд хүртээмжтэй, үнэнч шударгаар хүргэж оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх чадварлаг, үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 292.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	132.9	730.0	597.1
Бараа материал	16,693.1	17,868.9	1,175.8
Үндсэн хөрөнгө	715,302.9	674,437.7	-40,865.2
Нийт хөрөнгө	732,128.8	693,036.6	-39,092.2
Өр төлбөр	259.2	30.0	-229.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	731,869.7	693,006.6	-38,863.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	732,128.8	693,036.6	-39,092.2

Авлага дансны үлдэгдэл 597.1 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 1,175.2 мянган төгрөгөөр тус тус өссөн нь аудитын залруулгатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 40,865.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 229.2 мянган төгрөгөөр буурсан нь өр төлбөрийг барагдуулсантай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 38,863.1 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 292,493.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 292,493.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 262,738.0 мянган төгрөгийн, урд оны үлдэгдлээс 30,118.6 мянган төгрөгийн, нийт 292,856.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 292,248.0 мянган төгрөгийг зарцуулж, 608.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Засгийн газраас усны үнийн хөнгөлөлтөд 4,886.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 6,032.8 мянган төгрөгийн, нийт 10,555.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос 5,000.0 мянган төгрөгийг Отгонтэнгэр уулын тахилгын арга хэмжээнд, 1000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 4,000.0 мянган төгрөгийг ковидын зардалд, 555.4 мянган төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулаагүй, худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, эд хариуцагч болон жолоочтой тооцоо бодож хэвшээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

ЗДТГ-ын дарга нь батлагдсан орон тооноос 1 гэрээт ажилтанг илүү ажиллуулснаар Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эд хариуцагчид ажил хавсарсны нэмэгдлийг олгон, хариуцсан ажлыг нь сайжруулах үүрэг өгөн биелэлтийг тооцох, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 38.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.6 сая төгрөгийн алдааг залруулж, 23.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулгад 9.7 сая төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 2.9 сая төгрөгийн, санхүүгийн байдлын тайланд 0.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Ажилтнуудад илүү тооцож олгосон 1.3 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг аудитын хугацаанд сумын ЗДТГ-ын дансанд барагдуулсан.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 15.9 сая төгрөгийн зардлын анхан шатны баримт /и-баримт/-ыг бүрэн бүрдүүлээгүй;
- ✓ 2.3 сая төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг жолооч бичээгүй, эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- ✓ Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулах, эд хариуцагчаар хөрөнгийг бэлтгүүлэн, бараа материалын тайланг хугацаанд нь гаргуулан, тооцоо бодож хэвших

2. Арвилан хэмнэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

- ✓ Батлагдсан орон тооноос 1 гэрээт ажилтанг ажиллуулан 5.6 сая төгрөгийн цалин олгож, үрэлгэн зардал гаргасан;

2.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Асгат сумын ЗДТГ	7	38.4	4	14.6					3	23.8